



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АУДИТЫН КОД: ХЭА-2023/08/СТА-ТТЗ

Чингис хот 2023 он

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Цахим хуудас: www.audit.mn Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа

Утас: 99569599

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.04 № 329
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 1,076,478.8 мянган төгрөг, авлага 352,978.8 мянган төгрөг, бараа материал 152,093.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 6,787,539.5 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 8,369,090.4 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 976,447.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 1,209,344.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,240,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 259,624.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 37,123.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 46,570.4 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэж ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,761,316.19	1,581,550.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	974,578.02	1,076,478.82
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	974,578.02	1,076,478.82
3121	Төгрөг	969,344.21	1,071,459.19
31211	Төрийн сангийн харилцах	936,947.60	1,069,055.90
31213	Арилжааны банк дахь харилцах	32,028.04	2,403.29
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	368.57	-
3122	Гадаад валют	5,233.81	5,019.63
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	5,233.81	5,019.63
33	АВЛАГА	440,975.00	352,978.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,948.10	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	216,042.30	
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	595.35	
335	Бусад авлага	18,743.97	3,709.00
3351	Байгууллагаас авах авлага	12,954.97	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,789.00	3,709.00
336	Зээлийн авлага	203,645.28	349,269.82
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	203,645.28	349,269.82
33612	Хувь хүмүүст олгосон зээл	203,645.28	219,727.32
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		129,542.50
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	345,763.17	152,093.26
351	Түүхий эд материал	65,472.00	258.90
35110	Тусгай зориулалттай материал	2,622.70	258.90
35130	Эм боох материал	62,849.30	
354	Хангамжийн материал	186,596.17	74,284.36
35410	Бичиг хэргийн материал	11.51	937.70
35420	Аж ахуйн материал	75.78	30,845.41
35430	Сэлбэг хэрэгсэл	1,030.00	
35450	Барилгын засварын материал	852.00	
35460	Хүнсний материал	13,604.52	
35470	Бусад хангамжийн материал	171,022.36	42,501.25
35600	Мал амьтад	82,675.00	59,950.00
36	НӨӨЦИЙН БАРАА	11,020.00	17,600.00
36300	Тэжээлийн нөөц	11,020.00	17,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,926,727.05	6,787,539.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,926,727.05	6,787,539.53
392	Биет хөрөнгө	13,786,874.17	6,768,909.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,484,300.18	5,036,977.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(807,206.27)	(588,053.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	456,136.49	296,070.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	(206,581.66)	(153,312.14)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,022,970.27	326,369.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(532,773.13)	(154,210.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	337,731.09	32,486.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(214,763.22)	(27,416.15)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,374,970.59	2,374,970.59
39210	Хуримтлагдсан элэгдэл	(241,593.89)	(419,187.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	125,628.88	79,238.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,831.81)	(35,024.45)
39217	Ном	56,886.65	
393	Биет бус хөрөнгө	139,852.88	18,630.00
39301	Програм хангамж	2,864.50	1,244.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,385.62)	(1,194.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	139,374.00	18,580.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,688,043.24	8,369,090.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,307.41	-

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,307.41	-
413	Өглөг	5,307.41	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,761.21	-
4136	Бусад өглөг	2,546.20	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,546.20	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,769,948.04	8,369,090.42
51	Засгийн газрын хувь оролцоо	15,769,948.04	8,369,090.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,101,033.74	537,143.57
51101	Өмч: - төрийн	3,101,033.74	537,143.57
512	Хуримтлагдсан үр дүн	11,731,020.76	7,628,653.27
51210	Өмнөх үеийн үр дүн	11,277,380.90	14,865,793.61
51220	Тайлант үеийн үр дүн	453,639.86	(7,237,140.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	937,893.54	203,293.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,775,255.45	8,369,090.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,363,790.78	6,294,843.71
11	ТАТВАРЫН ОРЛОГО	750,574.00	1,190,474.83
110	Орлогын албан татвар	94,333.52	324,088.97
1100	Хувь хүний орлогын албан татвар	94,333.52	324,088.97
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		207,399.54
110002	Үйл ажиллагааны орлого	39,810.47	78,325.00
110003	Хөрөнгийн орлого	51,629.05	32,587.93
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,480.00	5,776.50
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	414.00	
113	Хөрөнгийн албан татвар	148,565.70	137,508.66
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		9,714.36
113002	Бууны албан татвар	5,394.00	5,220.00
113004	Малд ногдуулах албан татвар	143,171.70	122,574.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	507,674.78	728,877.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,096.95	14,621.02
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,456.45	2,483.42
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,950.00	1,500.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,690.50	10,637.60
1181	Газрын төлбөр	6,211.55	42,213.79
118101	Газрын төлбөр	6,211.55	42,213.79
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	491,366.28	672,042.39
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	490,593.98	665,491.79
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	772.30	6,550.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	628,683.15	1,303,712.68
120	Нийтлэг татварын бус орлого	628,683.15	1,303,712.68
120002	Хүүгийн орлого		35,768.84
120003	Торгуулийн орлого	7,920.25	6,642.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	532,419.21	1,141,190.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		43,197.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,127.74	38,162.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	502,291.47	1,059,829.88
120009	Бусад орлого	23,356.85	12,227.62
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	64,986.85	107,883.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,984,533.62	3,800,656.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,376,451.40	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,376,451.40	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	506,211.58	35,043.68
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,770.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,886.13	13,511.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,513.15	21,532.08
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	216,042.30	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,054,248.75	3,765,612.52
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,837,776.00	2,285,227.93
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	146,573.05	259,624.09
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	894,392.70	976,447.60

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	175,507.00	244,312.90
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	47,621.90	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	47,621.90	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,603,310.46	4,535,699.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,603,310.46	4,535,699.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,406,931.90	1,975,258.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,199,265.61	699,224.87
210101	Үндсэн цалин	1,616,363.66	313,829.10
210102	Нэмэгдэл	373,794.34	292,347.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,663.99	308.00
210104	Урамшуулал	189,782.79	8,387.51
210105	Гэрээт ажлын хөлс	13,660.84	84,353.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,537.68	56,854.69
210201	Тэтгэврийн даатгал	208,603.31	38,901.96
210202	Тэтгэмжийн даатгал	21,681.49	4,435.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,547.95	3,653.07
210204	Ажилгүйдлийн даатгал	4,175.15	879.92
210205	Эрүүл мэндийн даатгал	41,529.79	8,984.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	521,806.04	300,672.20
210301	Гэрэл, цахилгаан	40,469.55	38,728.53
210302	Түлш, халаалт	479,305.94	257,083.67
210303	Цэвэр, бохир ус	2,030.55	4,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	156,408.66	86,373.09
210401	Бичиг хэрэг	14,499.56	6,217.50
210402	Тээвэр, шатахуун	92,975.46	66,132.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,053.51	2,649.29
210404	Ном, хэвлэл	5,448.74	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,602.15	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,484.00	11,373.86
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,345.25	
2105	Нормативт зардал	268,596.76	1,030.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	176,859.44	
210502	Хоол, хүнс	86,156.53	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,580.80	1,030.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,031.54	27,182.02
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,807.00	320.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60.00	
210604	Урсгал засвар	44,164.54	26,862.02
2107	Томилолт, зочны зардал	11,463.48	5,525.00
210702	Дотоод албан томилолт	11,463.48	5,525.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,064.51	262,949.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,389.77	69,643.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,320.00	820.60
210803	Даатгалын үйлчилгээ	685.63	593.58
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350.68	402.65
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.00	42.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.00	
210807	Газрын төлбөр	260.94	691.30
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	8,726.52	
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	27,009.87	69,636.95
210813	Бусад зардал /ТӨҮГ/	16,055.11	121,118.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	804,757.61	535,446.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,630.77	140,306.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,066.87	24,424.25

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	643,059.97	370,714.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,378.56	2,560,440.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,023.16	58,284.05
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,850.53	31,419.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,998.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,172.63	6,866.05
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.20	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.20	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,984,582.58	2,502,156.39
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,837,776.00	2,240,800.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,573.05	259,624.09
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	233.53	1,732.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,772.62	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,772.62	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	760,480.32	1,759,144.47
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,885.13	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,885.13	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	311,725.57	8,996,284.81
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,081.97	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		110,840.04
225006	Үнэ төлбөргүй гарсан зардал Үндсэн хөрөнгө	268,183.90	8,593,795.19
225007	Үнэ төлбөргүй гарсан зардал Бараа материал	5,459.70	291,649.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(306,840.44)	(8,996,284.81)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	453,639.88	(7,237,140.34)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,814,502.32	5,217,989.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	750,574.00	1,190,474.83
110	Орлогын албан татвар	94,333.52	324,088.97
1100	Хувь хүний орлогын албан татвар	94,333.52	324,088.97
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		207,399.54
110002	Үйл ажиллагааны орлого	39,810.47	78,325.00
110003	Хөрөнгийн орлого	51,629.05	32,587.93
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,480.00	5,776.50
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	414.00	
113	Хөрөнгийн албан татвар	148,565.70	137,508.66
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		9,714.36
113002	Бууны албан татвар	5,394.00	5,220.00
113004	Малд ногдуулах албан татвар	143,171.70	122,574.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	507,674.78	728,877.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,096.95	14,621.02
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,456.45	2,483.42
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,950.00	1,500.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,690.50	10,637.60
1181	Газрын төлбөр	6,211.55	42,213.79
118101	Газрын төлбөр	6,211.55	42,213.79
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	491,366.28	672,042.39
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	490,593.98	665,491.79
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	772.30	6,550.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,270.54	269,205.87
120	Нийтлэг татварын бус орлого	255,270.54	269,205.87
120003	Торгуулийн орлого	7,920.25	6,642.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	159,006.59	98,024.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,878.86	20,430.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,127.74	38,162.50
1200047	шилжиж ирсэн мөнгө		39,431.79
120009	Бусад орлого	23,356.85	12,227.62
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	64,986.85	107,883.66
120017	Татаас санхүүжилтийн орлого ТӨҮГ		44,427.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,808,657.78	3,758,308.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,376,451.40	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,376,451.40	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,335.73	37,123.68
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,770.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	240,191.58	13,511.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,374.15	23,612.08
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,054,248.75	3,721,184.62
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,837,776.00	2,240,800.04
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	146,573.05	259,624.09
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	894,392.70	976,447.60

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	175,507.00	244,312.90
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	47,621.90	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	47,621.90	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,058,272.28	4,212,954.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,058,272.28	4,212,954.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,847,653.58	1,606,878.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,200,989.80	491,557.05
210101	Үндсэн цалин	1,604,043.43	331,745.18
210102	Нэмэгдэл	396,460.91	63,536.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,663.99	308.00
210104	Урамшуулал	189,152.05	11,985.03
210105	Гэрээт ажлын хөлс	5,669.42	83,982.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,112.95	63,135.37
210201	Тэтгэврийн даатгал	207,854.74	43,289.94
210202	Тэтгэмжийн даатгал	21,106.23	4,945.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,071.27	4,061.28
210204	Ажилгүйдлийн даатгал	4,050.75	974.50
210205	Эрүүл мэндийн даатгал	42,024.69	9,864.04
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	5.28	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	581,591.09	558,652.78
210301	Гэрэл, цахилгаан	40,469.55	50,897.56
210302	Түлш, халаалт	539,090.99	502,506.22
210303	Цэвэр, бохир ус	2,030.55	5,249.00
2104	Хангамж, бараа материалын зардал	152,905.94	143,950.49
210401	Бичиг хэрэг	14,469.39	7,810.60
210402	Тээвэр, шатахуун	65,838.41	56,093.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,565.76	2,426.68
210404	Ном, хэвлэл	4,971.50	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,273.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,702.02	7,982.65
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	34,085.86	69,636.95
2105	Нормативт зардал	286,076.39	1,030.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	202,671.43	
210502	Хоол, хүнс	74,189.66	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,215.30	1,030.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,909.21	54,501.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,091.20	8,539.20
210602	Тавилга	10,747.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,189.80
210604	Урсгал засвар	45,071.01	44,772.01
2107	Томилолт, зочны зардал	11,343.48	6,429.00
210702	Дотоод албан томилолт	11,343.48	6,429.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,837.26	135,266.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,232.99	128,947.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,320.00	1,408.60
210803	Даатгалын үйлчилгээ	685.63	675.25
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350.68	321.35
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.00	163.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.00	
210807	Газрын төлбөр	260.94	1,011.22
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	6,721.02	2,739.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,887.47	152,355.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	152,563.59	131,424.78

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,323.88	20,930.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,210,618.70	2,606,075.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,663.30	57,348.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,072.22	31,419.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,998.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,591.08	5,930.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,600.20	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,600.20	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,984,582.58	2,502,156.39
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,837,776.00	2,240,800.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,573.05	259,624.09
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	233.53	1,732.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,772.62	46,570.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,772.62	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		46,570.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	756,230.04	1,005,034.53
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	484,778.40	774,633.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	484,778.40	774,633.74
2200	Дотоод эх үүсвэрээр	484,778.40	774,633.74
223001	Бусад хөрөнгө	271,837.90	470,157.90
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	212,940.50	304,475.84
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(484,778.40)	(774,633.74)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	128,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл		128,500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	(128,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	271,451.64	101,900.79
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	703,126.42	974,578.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	974,578.06	1,076,478.84

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,105,890.31	938,260.64	11,277,013.81	15,321,164.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	367.10	367.10
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,105,890.31	938,260.64	11,277,380.91	15,321,531.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(367.10)	-	(367.10)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	(4,856.57)	-	-	(4,856.57)
Тайлант үеийн үр дүн	-	-	453,639.87	453,639.87
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,101,033.75	937,893.54	11,731,020.78	15,769,948.06
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,101,033.75	937,893.54	11,731,020.78	15,769,948.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,563,890.17)	(734,599.96)	3,065,344.88	(233,145.25)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,143.57	203,293.58	14,796,365.66	15,536,802.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	69,427.95	69,427.95
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(7,237,140.34)	(7,237,140.34)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,143.57	203,293.58	7,628,653.27	8,369,090.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,703,946.80	2,341,013.23	362,933.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,658,523.90	1,437,879.49	220,644.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,599,943.80	1,381,000.53	218,943.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	475,078.10	440,513.37	34,564.74
210101	Үндсэн цалин	242,224.10	284,625.64	(42,401.54)
210102	Нэмэгдэл	91,114.60	59,612.57	31,502.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,032.00	308.00	3,724.00
210104	Урамшуулал	16,147.90	11,985.03	4,162.87
210105	Гэрээт ажлын хөлс	121,559.50	83,982.13	37,577.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,732.80	56,782.67	2,950.13
210201	Тэтгэврийн даатгал	40,614.10	38,901.96	1,712.14
210202	Тэтгэмжийн даатгал	4,750.20	4,435.23	314.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,800.30	3,652.97	147.33
210204	Ажилгүйдлийн даатгал	952.00	879.92	72.08
210205	Эрүүл мэндийн даатгал	9,616.20	8,912.59	703.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	716,991.50	558,652.78	158,338.72
210301	Гэрэл, цахилгаан	52,782.80	50,897.56	1,885.24
210302	Түлш, халаалт	658,810.10	502,506.22	156,303.88
210303	Цэвэр, бохир ус	5,398.60	5,249.00	149.60
2104	Хангамж, бараа материалын зардал	52,900.40	52,191.74	708.66
210401	Бичиг хэрэг	6,564.80	6,710.60	(145.80)
210402	Тээвэр, шатахуун	34,788.50	35,479.20	(690.70)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,689.10	2,169.29	1,519.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,858.00	7,832.65	25.35
2105	Нормативт зардал	1,091.90	1,030.60	61.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,091.90	1,030.60	61.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,751.40	48,715.01	2,036.39
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,250.00	8,219.20	30.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,631.80	1,189.80	442.00
210604	Урсгал засвар	40,869.60	39,306.01	1,563.59
2107	Томилолт, зочны зардал	5,920.20	5,525.00	395.20
210702	Дотоод албан томилолт	5,920.20	5,525.00	395.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,844.70	102,655.29	16,189.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,276.10	100,150.16	15,125.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,445.50	820.60	624.90
210803	Даатгалын үйлчилгээ	661.90	593.58	68.32
210804	Тээврийн хэрэгслийн татвар	306.00	278.85	27.15
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134.50	120.80	13.70

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250.00		250.00
210807	Газрын төлбөр	770.70	691.30	79.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,632.80	114,934.09	3,698.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,593.30	94,003.44	1,589.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,039.50	20,930.65	2,108.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,580.10	56,878.95	1,701.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,580.10	56,878.95	1,701.15
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,419.20	31,419.20	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,998.80	19,998.80	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,162.10	5,460.95	1,701.15
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	861,658.80	774,633.74	87,025.06
2200	Дотоод эх үүсвэрээр	861,658.80	774,633.74	87,025.06
223001	Бусад хөрөнгө	861,658.80	774,633.74	87,025.06
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	183,764.10	128,500.00	55,264.10
230001	Эргэж төлөгдөх зээл	183,764.10	128,500.00	55,264.10
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,703,946.80	2,275,433.16	428,513.64
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,344,729.90	2,227,774.65	116,955.25
132001	Орон нутгийн төсвөөс	2,100,417.00	1,983,461.75	116,955.25
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	244,312.90	244,312.90	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	359,216.90	47,658.51	311,558.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.00	18,744.31	11,255.69
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,162.00	28,914.20	(752.20)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	301,054.90		301,054.90
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		301,376.34	(301,376.34)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		235,796.27	(235,796.27)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,492,252.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,492,252.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,492,252.11
210105	Гэрээт ажлын хөлс	
210205	Эрүүл мэндийн даатгал	
2104	Хангамж, бараа материалын зардал	2,748,000.00
210401	Бичиг хэрэг	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,248,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	
210604	Урсгал засвар	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,593,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,593,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,418,892.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,418,892.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,732,260.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,732,260.00
226001	Гадаад эх үүсвэрээр	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,123,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,123,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,511,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,612,080.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(368,572.11)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	368,572.11
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Өмнөдөлгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага-4, төрийн сангийн-1, тусгай сангийн-3 нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, төрийн сан, Өмнөдөлгөр нийтлэг үйлчилгээний санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийв.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,350.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Хэнтий шинэс сум дундын ойн анги нь биетээр авсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 171,792.7 мянган төгрөгийн 12 зөрчил илрүүлснээс, 3,083.7 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт, 13,921.2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 154,787.7 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. Үүнд

1. Засаг даргын тамгын газрын зарцуулалтад түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 2,702.0 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

2. Засаг даргын тамгын газар нь төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 208.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3. Засаг даргын тамгын газрын шатахуун зарцуулалтын анхан шатны баримтаар 578.7 мянган төгрөгийн шатахууныг жишиг нормоос хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалын 3-р хавсралтаар батлагдсан "Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ" зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

4. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь хүчин төгөлдөр бус баримтаар 284.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

5. Иргэдийн төлөөлөгчдийн хурал тайлант онд анхан шатны баримт, шийдвэргүйгээр 900.0 мянган төгрөгийн сургалтын төлбөр шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

6. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь сумын Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зардалд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй 6,750.0 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ы 3.7 "Төлөөлөгчийн үйл ажиллагаа, чадавхжуулах арга хэмжээнд шаардагдах зардлын төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа төлөөлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт зардлыг тухай бүр олгоно", 4.1 "Төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Хурлын ажлын албанд тухай бүр гаргаж өгнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

7. Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл 1,113.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн

захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдээдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

8. Орон нутгийн хөгжийн сангийн зарцуулалтад түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 82,588.57 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын “Маягт заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

9. Хэнтий шинэс сум дундын ойн ангийн зардлын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 22,070.0 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын “Маягт заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

10. Хэнтий шинэс сум дундын ойн анги тайлант онд 2,019.6 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт, гарын үсэг дутуу баримтаар зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт

нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

11. Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээний зарцуулалтад түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 47,427.1 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын “Маягт заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах улсын төсвийн 4 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийв.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 109,014.9 мянган төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

Эрүүл мэндийн төв нь шийдвэр гарсан хугацаанаас өмнө 102,947.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласныг хөрөнгөнд, илүү шилжүүлсэн ХХОАТ-ыг авлагад, үнэ төлбөргүй орлогоор бүртгэж тус тус залруулав.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,300,072.05 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлснээс, 203.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,832,907.7 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 466,9617.2 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. Үүнд

1. Цэцэрлэг нь Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 75,091.2 мянган төгрөгийн 6 гүйлгээ, орлогын 287,230.7 мянган төгрөгийн 25 гүйлгээг мэдээлээгүй, 21,180.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө

зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

2. Цэцэрлэгийн мөнгөн зардлын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 18,895.4 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

3. Цэцэрлэг нь тайлант хугацаанд ажилчдын цалингаас 8,706.9 мянган төгрөгийг хамтын сангийн суутгалд суутгасан. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд 119.1.1, 119.1.2, 119.1.3, 119.1.4-т заасан тохиолдолд суутгал хийж болно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

4. Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 299,882.5 мянган төгрөгийн 14 гүйлгээ, орлогын 1,498,230.7 мянган төгрөгийн 47 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

5. Ерөнхий боловсролын сургуулийн мөнгөн зардлын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 45,352.4 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг

нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

6. Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд ажилчдын цалингаас 19,080.4 мянган төгрөгийг хамтын сангийн суутгалд суутгасан. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд 119.1.1, 119.1.2, 119.1.3, 119.1.4-т заасан тохиолдолд суутгал хийж болно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

7. Ерөнхий боловсролын сургуулийн бараа материалын тайлангаар 203.1 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

8. Эрүүл мэндийн төв нь туслах аж ахуйн орлогыг анхан шатны баримт үндэслэн бүртгээгүйгээс 1,281.5 мянган төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 14 дүгээр зүйлийн 4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 -т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

9. Эрүүл мэндийн төв төсвийн хөрөнгөөр эмч нарын, хүүхдийн, ахмадын бэлэгт зориулан 5,726.7 мянган төгрөгийг зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

10. Эрүүл мэндийн төвийн мөнгөн зардлын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 19,211.2 мянган төгрөгийн

мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж

3.3. Өмнөдэлгэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын талаар:

Аудитаар нийт 46,570.4 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэхдээ мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 46,570.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг залруулсан.

Аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	10,198.7			1	46,570.4	1	10,198.7				
Хэнтий Шинэс сум дундын ойн анги	1	1,350.0	1	1,350.0			1	1,350.0				
Дүн	2	11,548.7	1	1,350.0	1	46,570.4	2	11,548.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	3	3,488.7	2	786.7			1	2,702.0				
ОНХС	1	82,588.5					1	82,588.5				
ИТХ	3	7,934.0	2	1,184.0	1	6,750.0						
БХС	1	1,113.0	1	1,113.0								
Нийтлэг үйлчилгээ	1	47,427.1					1	47,427.1				
ХШСДОА	2	24,089.6			1	2019.6	1	22,070.0				
Дүн	11	166,640.9	5	3,083.7	2	8,769.6	4	154,787.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				
							Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
ТХХ	1	5,151.6					1	5,151.6			
Дүн											
Нийт дүн	1	5,151.6					1	5,151.6			